

НИЙСЛЭЛИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ТӨВ

НИЙСЛЭЛИЙН ЦАХИМ ХУУДСАНД БҮРТГЭГДСЭН АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН

(2025 оны 01 дүгээр сарын 01-ээс 2025 оны 12 дугаар сарын 25 хүртэл)

2025 оны 12 дугаар сарын 25


Улаанбаатар хот

1. Шийдвэрлэсэн өргөдөл гомдлын тоо

Ангилал		Нийт		Шийдвэрлэх шатандаа байгаа						Шийдвэрлэж хариу өгсөн							
				Хугацаандаа байгаа		Хугацаа хэтэрсэн		Бүгд		Хугацаандаа шийдсэн		Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн		Бүгд			
				1=4+7		2		3		4=2+3		5		6		7=5+6	
				Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1800-1200 операатораас	Тоо	72	100.0	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00	72	100.0	72	100.0		
	Хувь	10.18	10.18	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00	10.18	10.18	10.18	10.18		
Засгийн газрын 11-11-с ирсэн	Тоо	518	100.0	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00	518	100.0	518	100.0		
	Хувь	73.27	73.27	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00	73.27	73.27	73.27	73.27		
ННЗБ бүртгэсэн	Тоо	116	100.0	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00	116	100.0	116	100.0		
	Хувь	16.41	16.41	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00	16.41	16.41	16.41	16.41		
E-Service	Тоо	1	100.0	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00	1	100.0	1	100.0		
	Хувь	0.14	0.14	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00	0.14	0.14	0.14	0.14		
Нийт	Тоо	707	100.0	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00	707	100.0	707	100.0		
	Хувь	100.0	100.0	0	0.00	0	0.00	0	0.00	0	0.00	100.0	100.0	100.0	100.0		

Дүгнэлт: 2024 оны мөн үед 1800-1200 операатораас 50 буюу 6.67%, ННЗБ-ээс 91 буюу 12.13% 11-11 төвөөс 609 буюу 81.20%, 750 өргөдөл, гомдол ирсэн байгааг энэ оны мөн үетэй харьцуулахад 43 тохиолдлоор буюу 6.08% буурсан.

Шийдвэрлэсэн өргөдөл гомдлын тоо, ирсэн хэлбэрээр



2. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хугацааны тайлан.

Д/д	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа	Хоног	Цаг	Минут	Нийт өргөдөл
1	2024 он	0	21	9	749
2	2025 он	0	21	51	707

Дүгнэлт: 2024 онтой харьцуулахад 43 өргөдөл гомдлын тоогоор буурсан ч шийдвэрлэсэн хугацааны хувьд ижил байна.

3. Хариу өгсөн хэлбэрийн тайлан.

Д/д	Хариу өгсөн хэлбэр	2024 он	2025 он
1	Программ хангамж+ Мессежээр хариу өгсөн	725	545
2	Программ хангамж+ Мессеж+Утсаар хариу өгсөн	24	124
3	Иргэнтэй биеэр уулзаж хариу өгсөн	-	38
	Дүн	749	707

Дүгнэлт: 2024 онд Программ хангамж+ Мессежээр хариу өгсөн тоо 725-аас 545 буюу 180-аар буурсан харагдаж байгаа ч иргэнтэй утсаар болон биеэр уулзаж хариу өгч байгаа байдал нэмэгдсэн нь иргэнтэй ярьж, уулзаж амьд харьцаа үүсгэн, сэтгэл ханамж нь дээшилсэн сайн тал харагдаж байна.

4. Өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн байдал

Д/д	Шийдвэрлэсэн байдал	2024 он	2025 он	Дүгнэлт: Нийт 98.44%-98.53% нь иргэний талд шийдсэн бол 1.46-1.55% нь шалгах боломжгүй, тусламж үйлчилгээний дагуу үйлчилсэн, үндэслэлгүй, хамааралгүй өргөдөл гомдол байсан.
	Ангилал	Тоо	Тоо	
1	Иргэний талд шийдвэрлэсэн	739	696	
2	Боломжгүй тухай хариу өгсөн өргөдөл гомдол	10	11	
	Дүн	749	707	



5. Өргөдөл, гомдлын төрлийн тайлан

Д/д	Байгууллага- Нийслэл Түргэн тусламжийн төв	Хүсэлт		Гомдол		Талархал		Санал		Мэдэгдэл		Нийт
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	
1	2024 он	94	12.53%	67	8.93%	586	78.13%	3	0.40%	0	0.00	750
2	2025 он	120	16.97%	39	5.52%	518	77.37%	1	0.14%	0	0.00	707

Дүгнэлт: 2025 онд хүсэлт 26-аар нэмэгдсэн бол гомдол 67-оос 28-аар буюу 71.7% буурсан сайн үзүүлэлт гарсан. Талархал урд оноос 68-аар буурсан байгаа ч нийт ирсэн өргөдөл гомдлын 77.8-78.13% талархал эзэлсэн хэвээр байна.

Төрлийн тайлан



6. Өргөдөл гомдлын хандалтын тайлан

Д/д	Ангилал	Өргөдөл, гомдлын тоо	Өргөдөл, Гомдлын хувь
1	2	3	4
1	Яаралтай тусламж, үйлчилгээний тухай	532	73.35%
2	Ажлаас чөлөөлөгдөх тухай	51	7.22%
3	Ажилд орох тухай	20	2.83%
4	Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай	13	1.84%
5	Цалинтай чөлөө хүсэх тухай	16	2.27%
6	Эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчийн ёс зүйн тухай	20	2.83%
7	Хоёр дахь шатлалын эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний тухай	5	0.71%
8	Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны тухай	26	3.68%
9	Өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай	4	0.57%
10	Ажилд шилжих, дэвшин ажиллах тухай	2	0.28%
11	Жирэмсний амралтын тухай	1	0.14%
12	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай	1	0.14%

1	2	3	4
13	Эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн тухай	1	0.14%
14	Эмийн сан, эмийн сангийн салбарын үйлчилгээний тухай	1	0.14%
15	Цалингүй чөлөө хүсэх тухай	13	1.84%
	Нийт өргөдөл, гомдлын дүн	706	100.00%

7.Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн нэгдсэн тайлан

Ангилал-Захиргаа	Нийт	Шийдвэрлэх шатандаа байгаа						Шийдвэрлэж хариу өгсөн							
		Хугацаандаа байгаа		Хугацаа хэтэрсэн		Бүгд		Хугацаандаа шийдсэн		Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн		Бүгд			
		1=4+7		2		3		4=2+3		5		6		7=5+6	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	2024 он	750	100.00%	1	0.13%	0	0.00%	1	0.13%	749	99.87%	0	0.00%	749	99.87%
2	2025 он	707	100.00%	0	0.00%	0	0.00%	0	0.00%	707	100.00%	0	0.00%	707	100.00%
Нийт өргөдөл, гомдол ирсэнийг 100.00% шийдвэрлэсэн.															

8.Зөрчлийн тоон үзүүлэлт

Д/д	Зөрчлийн төрөл	2025 оны зөрчлийн тоо		Дүгнэлт:
		С.Акерке	А.Алтанзагас	
	Нэрсээр			2024 онд зөрчлийн тоо 2 албан хаагчид нийлээд 17 байсан бол 2025 он 5 болж 240.0% буурсан. Цаашид зөрчилгүй нэмэхгүй бууруулж ажиллах зорилго тавин ажиллахаар шийдвэрлэсэн.
1	Өдөрт нь багтаан шилжүүлээгүй зөрчил	0	1	
2	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	0	2	
3	Явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчлийн тоо	2	0	
4	Буцаалтыг 3 хоногт хийгээгүй	0	0	
	Нийт	2	3	

9.Өргөдөл, гомдлын индексийн үнэлгээ:

Д/д	Албан хаагчийн нэр	Албан хаагчаар 2024 он	Албан хаагчаар 2025 он	Байгууллагаар 2024 он	Байгууллагаар 2025 он
1	Адьяасүрэн Алтанзагас	0.76	0.75	Тухайн 0.87	Тухайн 0.891
2	Сархад Акерке	0.65	0.68	Бүлэгт 0.88 Нийслэлд 0.89	Бүлэгт 0.90 Нийслэлд 0.87

1. Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн албан тушаалтад иргэдээс 2025 онд ирүүлсэн нийт 707 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирсэн. Үүнийг 2024 оны мөн үед 750 байсан буюу 43 тохиолдлоор буурсан.

2. Өргөдөл, гомдлын төрлийн тайлангаас харахад:

- Хүсэлт: 2025 онд хүсэлт 26-аар нэмэгдсэн бол
- Гомдол: 67-оос 28-аар буюу 71.7% буурсан сайн үзүүлэлт гарсан.
- Талархал урд оноос 68-аар буурсан байгаа ч нийт ирсэн өргөдөл гомдлын 77.8-78.13% талархал эзэлсэн хэвээр байна.


3. Талархал давхардсан тоогоор 304 дуудлагын эмч, ахлах эмч, сувилагч, 217 жолоочийн нэр дээр түргэн шуурхай ирсэнд, эмнэлэг хүргэсэнд, эмчилгээ, зөвлөгөө хийсэнд, эсэн мэнд амаржуулсанд, амь насыг аварсанд, зөвлөн тусалсанд талархсан талархлууд ирсэн.

4. Ирсэн 39 гомдлыг үзэхэд тусламж үйлчилгээний алдаа 18 буюу 46.15%

1. Харилцаа, хандлага, утсан харилцааны алдаа 15 буюу 38.46%, (үүнээс хүүхдийн дуудлага хүлээн авах нэгдсэн нэгжийн утсан харилцааны алдаа 9 буюу 23.07% байсан.)
2. Үндэслэлгүй буюу тусламж үйлчилгээний дагуу үйлчилсэн, боломжгүй, гомдлыг судалж шалгах боломжгүй 4 буюу 10.25%
3. Иргэн гомдлоо буцаасан 2 буюу 5.12%.
 - Тусламж үйлчилгээтэй холбоотой гомдлыг задалж үзэхэд ахлах эмчтэй холбоотой хүлээгдэл 3, тарилгатай холбоотой 1, нярайд өгөх зөвлөмж хангалтгүй, шар эрэмбэтэй иргэнийг эмнэлэг хүргээгүй, давтан дуудлагаар болон иргэнд газар дээрх тусламж үйлчилгээ хангалтгүй үзүүлсэн, бүрэн оношлоогүй асуудлууд байсан.
 - Харилцаа, хандлага, утсан харилцааны алдаа нь иргэнтэй боловсон зөв харьцаж, үгийг нь бүрэн сонсохгүй, хувийн ааш араншин гарган, зөв чиглэн туслаагүй, харьцахаас гадна хэцүү үйлчлүүлэгч зэрэг байсан.

Ирсэн өргөдөл, гомдлын дагуу байгууллага дараах ажлуудыг хийж, гомдлыг бүүрүүлж ажилласан. Үүнд:

Гомдлын дагуу ирсэн гомдлын удирдлагад танилцуулж, мөн өглөөний яриан дээр нийт эмч нарт 155 удаа танилцуулж, улирал бүр тохиолдолд суурилсан хэлэлцүүлэг хийж, үүнд иргэдээс ирсэн гомдлыг танилцуулж, зөвлөмж, сургалтыг ЭМТҮЧАБА-аас зохион байгуулан ажилласан.



- “Карте” системд “Файл админ”-ийн мэдээллийг салбар, ээлж, эмнэлгийн ажилчдад шуурхай илгээж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах нөхцөл бүрдүүлсэн. Алба, нэгжээс ирүүлсэн мэдээллийг эрх бүхий ажилтан оруулна. Тус хэсэгт 15 бүлэг байна. бүлэгт шинээр Ёс зүйн хэсгийн хороо, ХДХАНН-хүүхдийн дуудлага хүлээн авах нэгдсэн нэгж, шинэ ажилтны хөтөлбөр гэсэн файлыг шинээр нээж нийт

- Тушаал 1694 удаа
- Стандарт, удирдамж 1705 удаа
- Эмнэлзүйн заавар, тушаал 1610 удаа
- Түгээмэл үйлдлийн стандарт 643 удаа
- Журам 840 удаа
- Гарын авлага 514 удаа
- Сургалт 1107 удаа
- QR судалгаа 314 удаа
- Алгоритм 240 удаа
- Эмнэлэг хүргэх хуваарь 512 удаа
- Онош 773 удаа
- Зөвлөмж 1495 удаа
- Шалгуур, програм заавар 793 удаа
- Эрсдэлийн үнэлгээ 311 удаа
- Үйл ажиллагааны бүдүүвч зураг 294 удаа тус тус давхардсан тоогоор ахлах эмч, дуудлагын эмч, дагалдан эмч, сувилагч нар нийт 18 бүлгийн 12551 удаа мэдээллийг уншиж танилцсан байна. Хэн эмч орж, хэдэн удаа танилцсан тоо, хугацаа, нэрийн жагсаалтаар гарч ирдэг давуу талтай.

Файлын нэр	Огноо	Аймаг	Тусан
ЭМЧ-ын А587 тусламж.pdf	2025/08/04 09:47	Алтангадас	73
ЭМЧ-ын А160 тусламж.pdf	2025/08/04 09:58	Алтангадас	67
А297 Нарийн заавар, тушаал	2024/04/01 10:45	Алтангадас	185
А99 юуш тусламж.pdf	2025/04/18 12:40	Амарын	75
ЭМЧ-ын А06.pdf	2024/04/01 10:45	Алтангадас	72
А99 юуш тусламж мэдээлэл	2025/04/18 12:57	Эвандор	44
2025 01 03 Албан даалга	2025/07/01 14:46	Нарынбайгаль	67
Эрдэмтний сийрэг А-29	2024/07/26 10:10	Эвандор	219
ЭМЧ-ын А220 үйлдлийн стандарт	2024/04/01 10:45	Алтангадас	270
А-294 судалгаа танилцсан	2024/04/01 10:45	Алтангадас	292
А-91 туурвилга мэдээлэл	2025/07/01 08:53	Эвандор	91
— Гарын авлага А005			
А005-ийн ХДХАНН-ийн үйлдлийн стандарт	2025/01/30 10:24	Нарынбайгаль	40
ХДХАНН-2010 Алтангадас	2024/05/07 10:21	Эвандор	292
— Сургалт			
Эрдэмтний сийрэг-ийн үйлдлийн стандарт	2024/09/04 16:21	Нарынбайгаль	134
Мэдээлэл танилцаж	2024/12/26 09:14	Нарынбайгаль	190

- ХӨСҮТ-тэй хамтран 2025 оны 02-р сарын 06-ны өдөр зохион байгуулсан “Менингококкт халдвар болон салхинцэцэг өвчний оношилгоо, эмчилгээ, ялган оношилгоо” сэдэвт сургалтад 78 эмч хамрагдсан. Энэхүү сургалтыг ХӨСҮТ-ийн 5-р тасгийн эрхлэгч, АУ-ны доктор М.Оюунгэрэл удирдаж, онол, дадлага (тохиолдол, бодлого) хосолсон хичээл заасан бөгөөд сургалтад хамрагдсан эмч нарын менингококкт халдвар, салхин цэцэг өвчний оношилгоо, эмчилгээ, ялган оношилгоог хийх мэдлэг ур, чадвар нэмэгдсэн үр өгөөжтэй сургалт болсон талаар тайлан бичсэн.
- “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор Нийслэлийн түргэн тусламжийн төвийн эмч нарын түргэн тусламжийн үйлчилгээнд хэрэглэх эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, мэдлэг чадварыг нэмэгдүүлэхийн тулд “Эмийн зохистой хэрэглээ” сэдэвт сургалтыг 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрөөс 02 дугаар сарын 15-ны өдрүүдийн хооронд 5 салбарт хуваарийн дагуу 14 удаа амжилттай зохион байгуулсан. Тус сургалтыг АШУҮИС-ийн докторант, эм зүйч Б.Номин удирдаж, эмийн зохистой хэрэглээ, жор бичилтийн талаар онол, дадлага хосолсон хэлбэрээр явуулсан бөгөөд сургалтад нийт 108 эмч, 2 эм зүйч, 10 эм найруулагч хамрагдсан байна.
- НТТТ-ийн эмч, мэргэжилтнүүдийн эрдэм шинжилгээ, судалгаа хийх арга барилыг сайжруулах зорилгоор 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр Нийслэлийн Өргөө амаржих газрын хурлын зааланд зохион байгуулсан “Эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх арга зүй” сэдэвт сургалтад 75 эмч, мэргэжилтэн хамрагдсан. Тус сургалтыг АШУҮИС-ийн НЭМС-ийн Био-статистикийн тэнхимийн эрхлэгч АУ-ны доктор, дэд профессор Д.Гантуяа удирдаж, онол, дадлага хосолсон хэлбэрээр судалгааны загварууд хэрэглээ, судалгааны бүтээл бичих арга зүй, хиймэл оюун ухааныг судалгааны ажилд хэрхэн ашиглах талаар хичээл заасан.
- ЦТЭ-тэй хамтран 03-р сарын 13-ны өдөр баталсан удирдамжийг дагуу зохион байгуулсан “Нүүрстөрөгчийн дан исэл болон эм, химийн бодисын хордлогын үеийн түргэн тусламжийн үйлчилгээ” сэдэвт сургалтад 86 эмч хамрагдсан. Сургалтын мэдээллийг байгууллагын пэйж хуудаст нийтэлж <https://www.facebook.com/share/p/1HD8sh4mdg/?mibextid=wwXlfr>, тайлагнасан.
- Монголын Сувилагчдын нийгэмлэгтэй хамтран 03-р сарын 27-ны өдөр баталсан удирдамжийн дагуу зохион байгуулсан “Тарилга хийх арга техник- MNS4621:2008” сэдэвт сургалтад 85 эмч хамрагдсан.



- “Түргэн тусламжийн үйлчилгээнд зонхилон хийгддэг гардан үйлдлийн ур чадварыг нэмэгдүүлэх” сэдэвт сургалтыг зохион байгуулах тухай удирдамжийг 04-р сарын 10-ны өдөр батлуулсан. Энэхүү удирдамжийн дагуу СГХА нь ЭМТҮЧАБА, салбаруудтай хамтран 2025 оны 04 дүгээр сарын 11-ны өдрөөс 04 дүгээр сарын 30-ны өдрүүдэд зохион байгуулсан сургалтад нийт 145 эмч (Төв салбар- 32, БЗС-31, ЧС-24, ХУС-25, СХС-33) буюу 94.7%-ийн ирцтэй хамрагдсан. Сургалтын тайланг УЗ-ийн хуралд танилцуулсан.
- Нийслэлийн Хүрээ амаржих газартай хамтран 2025 оны 04-р сарын 23-ны өдөр тус амаржих газрын хурлын зааланд зохион байгуулсан “Жирэмсний аюултай шинж тэмдэг” сэдэвт сургалтад 89 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. Тус сургалтын онолын лекц, бодлого тохиолдлын хичээлийг НХАГ-ын Эмчилгээ эрхэлсэн дэд захирал, Эх барих эмэгтэйчүүдийн Зөвлөх зэргийн эмч Д.Цэцгээ удирдан заасан бөгөөд сургалтын үеэр эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээний эмнэлэг хүртэлх арга хэмжээг оновчтой, үр дүнтэй авах талаар хэлэлцүүлэг өрнүүлж, харилцан туршлага солилцсон, санал дэвшүүлсэн сургалт болсон нь онцлог байв.
- Зэлэм тархи сургалтын байгууллагатай хамтран 2025 оны 04 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан “Харилцан адилгүй зан төлөвийг удирдах нь сэдэвт сургалтад 27 албан хаагч хамрагдлаа. Энэхүү сургалтыг Зэлэм тархи сургалтын байгууллагын сургалт хариуцсан захирал, сургагч багш, көүч М.Оюун-Эрдэнэ удирдсан бөгөөд сургалтын үеэр захиргааны албан хаагчид өөрсдийнхөө зан төлөвөө тодорхойлж, харилцан адилгүй зан төлөвтэй хүмүүстэй хэрхэн үр дүнтэй харилцаж, ажлын бүтээмжээ сайжруулах арга барилд суралцсан үр өгөөжтэй сургалт боллоо.
- Нийслэлийн амаржих газрууд, ЭНЭҮТ-тэй хамтран 05-р сарын 12-ны өдрөөс 06-р сарын 09-ний өдрүүдэд зохион байгуулж буй “Эх барих, нярайн сэхээн амьдруулах тусламж, үйлчилгээний эмнэлзүйн ур чадварыг нэмэгдүүлэх нь” сэдэвт ажлын байрны сургалтад 153 эмч хамрагдаж байна.
- “Амилуулах болон лавшруулах суурь тусламж, үйлчилгээ” сургалтад дагалдан 27 эмч хамрагдсан бөгөөд сургалтын дараах сорилоор мэдлэгийн түвшин 75% дээш үнэлэгдсэнийг тайлагнасан.
- Олон Улсын байгууллагын EMS Global байгууллагатай уламжлал болсон түргэн тусламжийн 30 эмч, 30 жолооч нарыг чадавхжуулах эмнэл зүйн сургалтыг 8 өдрийн 64 цагийн сургалтыг амжилттай зохион байгуулсан.





- ГССҮТ-ийн яаралтай тусламжийн эмч Н.Наранхүүтэй СГХА хамтран “Осголт, тархи нуруу нугасны гэмтлийн үед үзүүлэх газар дээрх тусламж үйлчилгээ” сэдвээр цахим сургалтыг 9-р сард амжилттай зохион байгуулж, нийт 75 эмч нар хамрагдан мэдлэгээ бататгасан.
- ЭМТҮЧАБА, СГХА-аас болон ХАБ ажилтан нарын үйлчлүүлэгчийг аюулгүй тээвэрлэх ЭМС-ын тушаалд түшиглэсэн дадлага сургалтыг зохион байгуулсан үүнд баянзүрх салбарын 3 ээлжийн жолооч нар бүрэн хамрагдан суусан.



- Тусламж үйлчилгээнд явж байгаа 130 эмчийн яаралтай тусламжийн цүнхийг шинэчилсэн.
- Чагнуур 120 ширхэг, даралтын аппарат 200 ширхэг
- Нярайн болон хүүхдийн захын цусан дахь хүчилтөрөгчийн ханамжийг тодорхойлогч, пульсоксиметрийг 150 ширхэг
- Нярайн амьсгал тоологч 150 эмч нар хэрэглэж байна.
- 5 салбарт нийт 20 ширхэг дефибриляторыг худалдан авсан.

- Эх барихын багц 2024 онд 45 байсан бол 2025 онд 85 болгон нийт машин бүрт байршуулан, 2025 оны эхний 11 сарын байдлаар 43 эмнэлгийн бус Түргэн тусламжийн төрөлтөд очиж, үйлчилж, харьяа амаржих газруудад хүргэж, тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.



- Дуудлагын 74 автомашинд “Эх барихын багц”-ыг 2025 оны 3 дугаар улирлаас бүрэн шинэчлэн, үйл ажиллагаандаа хэрэглэн, нийт 43 түргэн тусламжийн төрөлтөд хэрэглэсэн байна.
- Эх барихын багцад нярайн жин болно хулдаасан метрийг шинээр хангаж бүрдүүлсэн.
- 2025 оны 05-р сард СХС, ХУС, ЧС нийт 75 цүнхийг шинэчлэн, эмийн сав, эмнэлгийн хэрэгслийн уут, тарианы цүнх, тарианы цүнхэнд өндөр эрсдэлт тэмдэглэгээг цүнхэнд нь байршуулан оёж шинэчилсэн.
- Чангалуурыг 120 ширхгийг шинээр хангаж өгсөн.
- Хүүхдийн тусламж үйлчилгээнд нярайн биеийн хэмжээг хэмжих жин 100 ширхэг (өртөг 2.500.000төгрөг), ампул хагалагч 150 ширхэг (2.250.000 төгрөг)-ийг дуудлагын эмч нарт тараан эмчилгээ үйлчилгээнд хэрэглэж эхэлсэн.
- Чингэлтэй салбарын нийт эмч нарт тохиолдлыг танилцуулж, анхааруулан, шүүмж хийж, үүрэг даалгавар өгөх. Эмч нартаа тухайн түлэгдлийн үеийн байдалтай мэдээллийг оруулж сургалт хийх, газар дээрх тусламжид юун дээр алдсан талаар мэдээлэл бэлдэх, мэдлэг ур чадвараа сайжруулах, оношилгоо эмчилгээг эмнэл зүйн зааврын тусламж үйлчилгээг үзүүлж, бичихийг анхааруулж хэвшсэн. Улмаар алдаа, эрсдэл гараагүй.
- Судас тодруулагчийг тусламж үйлчилгээнд нэвтрүүлсэн.
- Нүүрстөрөгчийн дан ислийн цочмог хордлогыг оношлох оношилгооны төхөөрөмжийг үйл ажиллагаанд нэвтрүүллээ. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр MASIMO RAD 57 Pulse CO-Oximeter 10 ширхгийг



түргэн тусламжийн үйлчилгээнд өнөөдрөөс ашиглаж эхэллээ. Уг аппарат нь угаарын хийн хордлогод өртсөн хүнд газар дээр нь оношилгоо хийж биеийн байдлыг үнэлснээр тусламж үйлчилгээний хожимдол үүсэхээс сэргийлэх боломжийг бүрдүүлэх юм.

Эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулсан ажлын хүрээнд:

Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн түүхт 95 жилийн ойг тэмдэглэх ажлын хүрээнд 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр ЭМЯ-ны хурлын Б зааланд зохион байгуулсан “Эрдмийн чуулган-2025” -д 110 эмч, зочид оролцож, 14 илтгэлийг хэлэлцүүлж, шилдэг 4 илтгэлийг шалгаруулсан. Тус чуулганы үйл ажиллагааг тайлагнаж, архивлаж, санхүүгийн нотлох баримт болох тул СБА-д хүргүүлсэн.



Энэхүү чуулганыг “Түргэн тусламжийн шинэчлэлд салбар хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэе” уриан дор Нийслэлийн Эрүүл мэндийн газар болон АШУҮИС-ийн Нийгмийн Эрүүл мэндийн сургуультай хамтран зохион байгуулсан билээ.

Чуулганы 2-р хэсэгт түргэн тусламжийн чиглэлээр хийсэн судалгааны ажлын 14 аман илтгэлийг хэлэлцүүлж, шилдэг 4 илтгэлийг шалгаруулсан. Үүнд:

- Тэргүүн байранд “Нийслэлийн төвийн зургаан дүүргийн хэмжээн дэх гэрийн төрөлтийн судалгаа” сэдвээр НТТТ-ийн Даатгал, статистик, мэдээллийн албаны дарга М.Наранбайгаль
- Дэд байранд “Артерийн гипертензийн эрсдэлтэй хүмүүсийн дотор өөхжилтийн индексэд нөлөөлөх хүчин зүйл” сэдвээр НТТТ-ийн ХУС-ын эмч С.Ганчимэг,
- Гутгаар байранд “Нийслэлийн түргэн тусламжийн төвийн дуудлагын тусламж үзүүлээд, нас барсан тохиолдлын судалгаа” сэдвээр НТТТ-ийн ЧС-ын ахлах эмч Б.Эрхэмболд
- Тусгай байранд “Хэвлийн цочмог өвдөлттэй, эзлэхүүн багасалтын шоктой өвчтөнд мобайл технологи ашиглан ivc үнэлж, эмнэлэг хүртэлх тусламж үйлчилгээг хугацаа алдалгүй үзүүлсэн тохиолдол” сэдвээр НТТТ-ийн ТС-ын эмч Х.Солонго тус тус шалгарсан.

2025 оны 10 дугаар сарын 23-нд эхний шатнаас шалгарсан 4 бүтээлээ шүүгч нарт танилцуулж ажилласан. Нийслэлийн эрүүл мэндийн газрын “Сайн туршлага 2025” үйл ажиллагаанд нийт 28 байгууллагын 2-р шатанд шалгарсан 81 бүтээлээс Нийслэлийн Түргэн тусламжийн төв Үйлчилгээ, тусламж үйлчилгээг хөнгөвчлөх чиглэлд “Автомашинь хар хайрцаг- дуу дүрсний хяналт” бүтээлээр “ДЭД БАЙР” эзэлсэн. Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсан.

Нийслэлийн эрүүл мэндийн газрын “Сайн туршлага 2025” үйл ажиллагааны заавал хэвшүүлэх 25 бүтээлд “Яаралтай тусламжийн эмийн гарын авлага” ном орсон амжилтуудыг гаргасан.



ТАЙЛАН ХЯНАСАН:
ДАРГА

С.АРИУНБОЛД

НЭГТГЭСЭН: ЭМТҮЧ АБАНЫ
МЕНЕЖЕР

З.ЭНХЦЭЦЭГ